



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 193

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн тогтолцоог хөгжүүлэх стратегийн хэрэгжилтийг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлийн төрөлжсөн програм хангамжийг эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх журмыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Ж.Хатанбаатар)-д даалгасугай.

САЙД



Н.УДВАЛ

001299

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛИЙН ТӨРӨЛЖСӨН ПРОГРАМ ХАНГАМЖИЙГ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД НЭВТРҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хөтлөгдөх анхан шатны бүртгэл, тайлангийн мэдээ мэдээллийг бэлтгэх эрүүл мэндийн чиглэлийн төрөлжсөн програм хангамжийг /цаашид “програм” гэх/ шалгаж, үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.

### Хоёр. Програмд тавигдах ерөнхий шаардлага

- 2.1. Програм нь дараах үндсэн шаардлагуудыг хангасан байна. Үүнд:
  - 2.1.1. Бүртгэлийн маягтад хэрэглэгдэх нэр томъёо нь эрүүл мэндийн мэдээний толь бичигтэй тохирч байх
  - 2.1.2. Бүртгэлийн болон тайлангийн маягт нь “Эрүүл мэндийн статистик мэдээллийн талаар авах зарим арга хэмжээний журам”-д, даатгалын болон санхүүгийн мэдээллийн маягт, дамжуулах файлын бүтэц нь ЭМЯ, НДЕГ болон СЯ-наас гаргасан журамд тус тус нийцсэн байх
  - 2.1.3. Хувь хүний нууцын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, ЭМЯ-наас батлан гаргасан “Эрүүл мэндийн салбарт мэдээллийн технологийн талаар мөрдөх журам”, “Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлын журам”-д нийцсэн байх
  - 2.1.4. Гараас оруулах дурын хоёр огнооны хооронд тайланг бодож гаргадаг байх
  - 2.1.5. Сүлжээний орчинд ажилладаг байх
  - 2.1.6. Програмд хэрэглэгч бүр өөрсдийн нэр, нууц үгээр ханддаг байх
  - 2.1.7. Гарын авлага нь цахим болон цаасан хэлбэртэй байх
  - 2.1.8. Үр дүнг хэвлэх боломжтой байх
  - 2.1.9. Өгөгдлийг хэрэглээний энгийн бусад програм хангамж болох Microsoft Word, Excel програм уруу хөрвүүлэн гаргадаг байх

### Гурав. Програмыг шалгах

- 3.1. Эрүүл мэндийн байгууллага нь програм хангамжийг шалгах ажлыг бие даан зохион байгуулах ба үр дүнг Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн дэргэдэх техникийн ажлын хэсгээр хянуулж дүгнэлт гаргуулна.

- 3.2. Эрүүл мэндийн байгууллага нь зайлшгүй шаардлагатай тохиолдолд мэргэжлийн шинжээчдийг гаднаас авч ажиллуулж болно. Мэргэжлийн шинжээчид нь програм хангамжийн гүйцэтгэгчтэй ашиг сонирхолын зөрчилгүйг нотолсон мэдүүлэг өгсөн байна.
- 3.3. Эрүүл мэндийн байгууллага нь програм хангамжийг шалгахын тулд програмыг нарийвчлан судлах бололцоо олгохыг програм зохиогчоос шаардах эрхтэй.
- 3.4. Эрүүл мэндийн байгууллага нь програмын нууцыг задруулж үл болно.
- 3.5. Эрүүл мэндийн байгууллага нь Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн програм хангамжийг албан ёсоор үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.

### **Дөрөв. Програм хангамжийг шалгах аргачлал**

- 4.1. Програмд нэвтрэх хандалт, хэрэглэгчийн эрхийн зохицуулалтыг шалгах

*Зорилго:* Програмд нэвтрэх хэрэглэгчийн хэсэг, хэрэглэгчийн эрхийг зохицуулах хэсгийн үйл ажиллагааг шалгах

*Шалгах үйл ажиллагаа:*

- 4.1.1. *Хэрэглэгч үүсгэх, нэвтэрч орох, идэвхгүй болгох үйл ажиллагааг шалгах*  
Програм хангамжид нэвтрэх эрх бүхий хэрэглэгчийг шинээр үүсгэж туршихдаа дараах үйлдлийг гүйцэтгэнэ.

- Шинээр хэрэглэгч үүсгэх
- Зориуд бэлтгэсэн ижил нэр бүхий хэрэглэгчийг үүсгэж нэр давхацсан тухай алдааны мэдээлэл өгч байгаа эсэхийг шалгах
- Идэвхтэй хэрэглэгчийн нэр, нууц үг ашиглан програмд нэвтрэх
- Идэвхгүй болон бүртгэлгүй хэрэглэгчийн нэр, нууц үг ашиглан програмд нэвтрэх
- Нууц үгийн бодлогыг хэрэгжүүлсэн байдлыг шалгах. Үүнд:
  - хамгийн багадаа 10 тэмдэгт авдаг байх
  - толь бичигт байдаг үг ашиглахгүй байх
  - үсэг болон тоо хольсон байх
  - хэрэглэгч нууц үгээ солих боломжтой байх
- Програмаас гарах үйлдлийг шалгах /хэрэглэгч 3-5 минутын дотор програмд ямар нэгэн үйлдэл хийгээгүй тохиолдолд автоматаар гардаг байх, мөн гар аргаар програмаас гарч болдог байх/

- 4.1.2. Хэрэглэгчийн эрх олгох хэсгийн үйл ажиллагааг шалгах

- Хэрэглэгчдийн бүлэг үүсгэх

- Хэрэглэгчдийн бүлгийн эрхийг тодорхойлох /эрх олгох болон эрх хязгаарлах ажлыг классын түвшинд болон талбарын түвшинд турших/
- Идэвхтэй хэрэглэгчийн нэр, нууц үг ашиглан програмд нэвтэрч олгогдсон эрхийн дагуу ажиллаж байгааг шалгах
- Хэрэглэгчийг нэг бүлгээс нөгөөд шилжүүлэн турших
- Хэрэглэгчдийн бүлгийг устгах

#### 4.2. Үйлчлүүлэгчийн мэдээлэл оруулах, өөрчлөх, устгах

*Зорилго:* Үйлчлүүлэгчийн талаарх мэдээлэл оруулах хэсгийг турших, автоматаар болон зайлшгүй бөглөгдөх шаардлагатай талбарыг шалгах

*Шалгах үйл ажиллагаа:*

##### 4.2.1. Шинэ үйлчлүүлэгч бүртгэх /Тусгайлан бэлдсэн мэдээллийг оруулан турших/

- Үйлчлүүлэгчийн овог, нэр, регистрийн дугаар, нас, хүйс, оршин суух хаягийг програмд оруулах
- Заавал бөглөгдөх ёстой талбаруудын утгыг хоосон орхиж хадгалах үйлдлийг хийж турших /Заавал бөглөх шаардлагатай мэдээллийг хүснэгт-1 ээс харах/
- Дутуу орхигдсон мэдээллийн талаарх анхааруулга өгч байгаа эсэхийг шалгах
- Регистрийн дугаар оруулсан тохиолдолд нас, хүйс автоматаар бөглөгдөж байгаа эсэхийг шалгах
- Өмнө үүссэн үйлчлүүлэгчийг зориуд давхардуулан оруулж, давхардсан талаарх алдааны мэдээллийг өгч байгаа эсэхийг шалгах

Хүснэгт-1. Үйлчлүүлэгчийн мэдээллийн талбар, түүний авах утгад тавигдах нөхцөл

|    | Талбарын нэр      | Тодорхойлолт                  | Шалгах арга   | Заавал бөглөх эсэх |
|----|-------------------|-------------------------------|---|--------------------|
| 1. | Эцэг/Эхийн нэр    | Үйлчлүүлэгчийн Эцэг/Эхийн нэр |   | тийм               |
| 2. | Нэр               | Үйлчлүүлэгчийн нэр            |   | тийм               |
| 3. | Регистрийн дугаар | Үйлчлүүлэгчийн регистр        | Регистрийн дугаар доторх хяанлтын оронг шалгаж байгаа эсэхийг хянах                                       | тийм               |
| 4. | Нас               | Үйлчлүүлэгчийн нас            | - Үйлчлүүлэгчийн регистрийн дугаар болон төрсөн он сараас бодож байх<br>- сөрөг утгатай тоо байж болохгүй | тийм               |

|    |   |  |  |      |
|----|---|--|--|------|
| 5. | Хүйс                                    | Үйлчлүүлэгчийн хүйс                                      | Үйлчлүүлэгчийн регистрийн дугаараас бодож байх | тийм |
| 6. | Төрсөн огноо                            | Үйлчлүүлэгчийн төрсөн он сар өдөр                        | Одоогийн он сар өдрөөс хойш байж болохгүй      | тийм |
| 7. | Гэрийн хаяг /Байнга оршин суугаа хаяг/  | Үйлчлүүлэгчийн оршин суугаа газрын хаяг                  |  | тийм |
| 8. | Холбоо барих утас                       | Үйлчлүүлэгчийн хэрэглэдэг суурин болон гар утасны дугаар |  | тийм |
| 9. | Эрүүл мэндийн даатгалын дэвтрийн дугаар | Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн даатгалын дэвтрийн дугаар   |  | тийм |

4.2.2. Үүссэн үйлчлүүлэгчийн мэдээллийг засварлах

- Үйлчлүүлэгчийн мэдээллийг засварлах үйлдэл хийх
- Зассан тухай мэдээллийг Audit Log-оор бүртгэж байгаа эсэхийг шалгах /хуучин өгөгдөл, шинэ өгөгдөл, засварласан огноо, засварласан хэрэглэгчийн нэр/
- Үйлчлүүлэгчийн эмчид үзүүлсэн тэмдэглэлийг өөрчлөх
- Өөрчлөлт орж байгаа эсэхийг шалгах /Эмч үзлэгийг баталгаажуулсан нөхцөлд мэдээлэл дахин засагдахгүй байх ёстой/

4.2.3. Үйлчлүүлэгчийн мэдээллийг устгах

- Үүсгэсэн үйлчлүүлэгчийн мэдээллийг устгах үйлдлийг хийх
- Устгах явцад анхааруулах мэдээлэл өгч байгааг шалгах
- Устгасан тухай мэдээллийг Audit Log-оор бүртгэж байгаа эсэхийг шалгах /хуучин өгөгдөл, шинэ өгөгдөл, устгасан огноо, устгасан хэрэглэгчийн нэр/

4.3. Үйлчлүүлэгчийн цаг товлолт, түүнийг өөрчлөх, устгах /цаг товлолын хэсэгтэй програмын хувьд/

**Зорилго:** Үйлчлүүлэгчийн эмчид үзүүлэх захиалгыг үүсгэх, түүнийг өөрчлөх, устгах үйлдлийг турших

**Шалгах үйл ажиллагаа:**

- 4.3.1. Цаг товлолтын хэсэгт захиалга үүсгэх
- 4.3.2. Үүссэн захиалга холбогдох кабинетийн эмчид харагдаж буй эсэхийг шалгах
- 4.3.3. Нэг үйлчлүүлэгчид зарцуулах цагийн алхмыг цаг товлолтын хэсэгт гараас өөрчлөх боломжтой эсэхийг шалгах
- 4.3.4. Үүсгэсэн захиалгын цаг болон кабинетийг өөрчилж шалгах

#### 4.3.5. Хүлээгдлийн тайланг гаргахад шаардлагатай өгөгдлүүд байгаа эсэхийг шалгах

#### 4.4. Хайлт болон шүүлт

*Зорилго:* Програмаас шаардлагатай мэдээллийг хайж олох, нөхцөлт хайлтын үнэн зөв ажиллаж байгааг шалгах

*Шалгах үйл ажиллагаа:*

##### 4.4.1. Дурын утгаар хайх үйлдлийг шалгах /full text search/

- Үйлчлүүлэгчийн овог, нэрийг оруулж хайх
- Үйлчлүүлэгчийн регистрийг оруулж хайх
- Үйлчлүүлэгчийн төрсөн огноог оруулж хайх

##### 4.4.2. Тусгайлсан талбарын утгаар хайх үйлдлийг шалгах

- Үйлчлүүлэгчийн нэрийг оруулж хайлт хийх
- Үйлчлүүлэгчийн насыг оруулж хайлт хийх
- Үзсэн эмчийн нэрийг оруулж хайх

##### 4.4.3. Хэд хэдэн талбарын утгаар нөхцөл тавьж хайх үйлдлийг шалгах

- Үйлчлүүлэгчийн нэр, нас, хүйсийг зэрэг оруулж хайлт хийх
- Үзсэн эмч, үзсэн он сар өдрөөр эмчийн үзлэгийн мэдээллийг хайх

#### 4.5. Audit log

*Зорилго:* Мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн бүртгэл хөтлөгдөж байгаа эсэхийг шалгах

*Шалгах үйл ажиллагаа:*

##### 4.5.1. Мэдээлэл өөрчлөх үйлдлийг бүртгэх хэсгийг шалгах

- Үйлчлүүлэгчийн талаарх мэдээллийн зарим хэсгийг өөрчлөх, засварлах
- Өөрчлөгдсөн мэдээллийн хуучин утга, шинэ утга, засварласан огноо, засварласан хэрэглэгчийн нэрийг бүртгэж байгаа эсэхийг шалгах

#### 4.6. Анхааруулах болон алдааны мэдээлэл

*Зорилго:* Хэрэглэгчид мэдээллийг дутуу оруулахаас зайлхийх, гарсан алдааны талаарх мэдээллийг хэрэглэгчид ойлгомжтой хэлбэрээр мэдээлэх үйлдлийг шалгах

*Шалгах үйл ажиллагаа:*

##### 4.6.1. Дутуу орхигдсон мэдээллийн талаар анхааруулах үйлдлийг турших

- Зайлшгүй бөглөх шаардлагатай талбарын утгыг орхигдуулан хадгалах үйлдэл гүйцэтгэх
- Дутуу орсон мэдээллийг гүйцэд оруулахыг хэрэглэгчид сануулах, хадгалах үйлдлийг таслан зогсоож байгаа эсэхийг шалгах

4.6.2. Буруу өгөгдөл орсон талаарх алдааны мэдээллийг шалгах

- Хэрэглэгчийн хүйсийг гараас өөрчлөх үйлдэл хийх
- Хүйсийн талаарх мэдээлэл үнэн зөв эсэхийг үйлчлүүлэгчийн регистрийн дугаараас шалгаж алдаатай эсэхийг хэрэглэгчид мэдээлж байгааг шалгах

4.7. Мэдээллийн нууцлал, нөөцлөлт, хуулбарлалтыг шалгах

*Зорилго:* Өгөгдлийн сангийн нууцлалын байдал, нөөцлөлт, түүний хадгалалт хамгаалалтыг шалгах

*Шалгах үйл ажиллагаа:*

4.7.1. Өгөгдөл удирдах системийн нууцлалтыг шалгах

- Нууц үгийн бодлогыг хэрэгжүүлсэн байдлыг шалгах. Үүнд:
  - хамгийн багадаа 10 тэмдэгт авдаг байх
  - толь бичигт байдаг үг ашиглахгүй байх
  - үсэг болон тоо хольсон байх
- Өгөгдөл хадгалагдаж буй сервер компьютерт бусад ашиглагдаагүй портууд хаалттай байгаа эсэхийг шалгах

4.7.2. Өгөгдлийн санг өдөр бүр нөөцөлж байгааг шалгах

- Өгөгдлийн сангийн сүүлийн нөөцлөлтийн үүссэн огноог шалгах
- Өгөгдлийн санг нөөцөөс эргүүлэн сэргээх, бүрэн эсэхийг шалгах

4.7.3. Өгөгдлийн санг газар зүйн байршлын хувьд өөр өөр газарт хуулбарлаж байгааг шалгах

- Өгөгдлийн сангийн сүүлийн нөөцлөлтийн үүссэн огноог шалгах
- Өгөгдлийн санг нөөцөөс эргүүлэн сэргээж бүрэн эсэхийг шалгах

4.8. Тайлан хэвлэх

*Зорилго:* Хэрэглэгчид шаардлагатай мэдээлэл тайлан хэлбэрээр зөв гарч байгааг шалгах

*Шалгах үйл ажиллагаа:*

4.8.1. Тайлан үнэн зөв гарч байгаа эсэхийг шалгах /Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан маягтын дагуу/

4.8.2. Тайланг хэвлэхэд дараах мэдээлэл тайлангийн хамт хэвлэгдэж байгаа эсэхийг шалгана: Үүнд:

- Хэвлэсэн огноо
- Хэвлэсэн хүний нэр
- Тайлант огноо
- Хуудасны дугаар